

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (√) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	-Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулиудын төслийг боловсруулж Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлж, дээрх 2 хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх цааш хэлэлцэх эсэхийг дэмжүүлсэн болно. -Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулах, санал авах уулзалт хэлэлцүүлгийг МҮЭ, аймаг нийслэл, салбарын ҮЭ-ийн холбооны гишүүд, идэвхтэн сонгуультнуудад зохион байгуулав. МҮЭ-ийн холбооны 21 аймаг 14 салбарын гишүүн байгууллагын ҮЭ-ийн 600 орчим гишүүд танхим, цахим хэлбэрээр оролцов. √		√		
2.	"Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр"- т 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Прага хотноо гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрийг Монгол Улсын хувьд УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр соёрхон баталсан. Түүнчлэн 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх Удирдлагын тохиролцоонд гарын үсэг зурж хэлэлцээр хэрэгжих нөхцөл бүрдээд байна.			√	
3.	Дэлхийн Банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжихэд тэтгэврийн параметрийн өөрчлөлт, Нийгмийн даатгалын шинэчлэлтэй холбоотой сангуудад актуар тооцоолол хийж ажиллаж байгаа олон улсын зөвлөлтэй 2023 оны 01 дүгээр сарын 24, 31-ний өдрүүдэд тэтгэврийн тооцоолол хийх, өгөгдөл мэдээлэлтэй холбоотой асуудлаар цахим уулзалт зохион байгууллаа.			√	
4.	"Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөнөөр тооцох хугацааны шимтгэл төлөх журам"-ыг шинэчлэн батлах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/230 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
5.	"Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2020 оны 25 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 188 мянган төгрөгөөр тогтоосон. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 167 дугаар тогтоолын дагуу цар тахлын үед 288 мянган төгрөгөөр олгож байсан. Уг хууль тогтоомжийн үйлчлэх хугацаа дуусгавар болохтой холбоотой нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн хэмжээгээр олгохоор "Тогтоолд өөрчлөлд оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан юм.		√		
6.	Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан "Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай" хууль, "Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга		√		

	хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 11 дүгээр тогтоолоор батлуулав. Энэхүү журмаар нийт хүүхдийн 91 хувьд хүүхдийн мөнгийг хэрхэн олгох, мөн хүүхдийн мөнгийг анх удаа захиргааны мэдээлэлд тулгуурлаж өрхийн амьжиргааг үнэлж, олгох гэж байгаатай холбоотой төрийн байгууллагууд хоорондын мэдээллийн зөрүүтэй байдлын уялдаа, холбоог зохицуулах, зөрүүтэй мэдээллийг тухайн иргэний хүсэлтэд үндэслэн залруулах, хүүхдийн мөнгөтэй холбоотой өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан.				
7.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдсан аргачлал болон журмын төсөл боловсруулах дэд ажлын хэсэг орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулж, захиргааны өгөгдөлд үндэслэсэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалын төслийг шинээр боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр 02/132 дугаар бичгээр Үндэсний статистикийн хороонд хамтран батлуулахаар хүргүүлсэн. Үүний дагуу Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хурлаар тус аргачлалыг хэлэлцүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/16, А/04 дугаар тушаалаар батлуулсан.			√	
8.	“Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын төслийг эцэслэх ажлыг ЗГХЭГ-тай хамтран хийв.			√	
9.	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”-ыг Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг 05 дугаар тогтоолоор тус батлууллаа.		√		
10.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороогоор Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 14 аймгийн тогтоолыг албажуулан аймгуудад хүргүүлэв. Мөн “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ыг тус хороогоор батлуулан, ЖҮХ-ны ажлын албатай хамтран холбогдох бусад судалгаа, мэдээлэл танилцуулах семинарыг 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулав.			√	
11.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 1 дүгээр сарын 20-нд Улсын Их Хурлаас соёрхон баталсан. Хууль батлагдсанаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаанд дэвшил гарч, гадаад улсад хөдөлмөр эрхлэх, дадлагажихад зуучлах тусгай зөвшөөрөл олгох төрийн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой болох бөгөөд үйлчилгээний шуурхай байдал, чанар, хүртээмж нэмэгдэх болно. Түүнчлэн ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчийн төрд төлж байгаа гадаад ажилтны ажлын байрны төлбөр хөнгөлөгдөж, улмаар зардлаа хэмнэн эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын дараах сэргэлтийг эрчимжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.		√		
12.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т заасныг үндэслэн Засгийн газрын “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” 2023 оны 19 дүгээр тогтоолыг батлууллаа. Тус тогтоолоор гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 36 аж ахуйн нэгж, байгууллагын 5673 гадаад ажилтныг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт, олон улсын гэрээ, салбарын яам агентлагтай байгуулсан гэрээ хэлэлцээрийг үндэслэн 2023 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөллөө.			√	
13.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх, хувийн хэвшлийн гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлууллаа.		√		
14.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр			√	

	сарын 18-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Гадаадаас авах нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан.				
15.	“Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д 2007-2016 онуудад орсон нэмэлт, өөрчлөлт нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлгүй байсан тул эдгээр 4 тушаалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хэрэгжилтийг зохицуулахаар хүргүүлэв.			√	
16.	Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттай цахимжуулах ажлын хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас олгодог дэмжлэг, хөнгөлөлтийн үйлчилгээг халамжийн нэгдсэн систем ehalamj-д шилжүүлэн цахимаар үйлчилгээг хүргэж иргэн хүсэлтээ цахим хэлбэрээр гаргах, дэмжлэг хөнгөлөлт авахад төрийн байгууллага хооронд мэдээллийг системээр дамжуулан авах, иргэнээс давхар шаардахгүй байх, иргэний системд бүртгэлтэй данс руу Төрийн сангаар шууд шилжүүлэг хийх болсон болон бусад хэрэгжилтийн явцад иргэдэд хүндрэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1, 3, 5 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журам”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-ыг тус тус шинэчлэн боловсрууллаа. Журмын төсөлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, нийгмийн халамжийн анхан, дунд шатны байгууллага, агентлагийн саналыг тусгаад байна.			√	
17.	Нийгмийн халамжийн шинэчлэл, нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжилт, цаг үеийн өөрчлөлттэй холбоотойгоор төрд байгаа иргэний мэдээллийг үндэслэн үйлчилгээг үзүүлэх, хүндрэл чирэгдлийг багасгах зорилгоор 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 362 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулж яамны холбогдох газруудад танилцуулан санал авч байна.			√	
18.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал батлуулсан.			√	
19.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж батлуулав.			√	
20.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг ХЗДХ-ийн сайд болон Сангийн сайдад хүргүүлсэн. Үүнтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж бүрдүүлбэрийг бэлтгэж байна.			√	
21.	Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж байна.				√
22.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, нөхцөл байдлын судалгаа хийсэн.			√	
23.	Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцаж, нэг хүнд ногдох зардлын нормативын талаар Сангийн яамтай хамтарсан судалгаа хийж байна. Энэхүү ажлын байрны зураг авалтын дараа ХНХ-ын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын норматив”-ыг шинэчлэн батлах юм.			√	
24.	ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/173, А/120 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын маягтыг турших ажлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 22 болон 25-ны өдрүүдэд дүүрэг, хороодын Нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллалаа. Журмын төслийг эцэслэхээр бэлтгэж байна.			√	
25.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, Засгийн газрын гишүүдийн саналыг авч байна.			√	
26.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон өөрчлөлттэй холбоотой үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны төслүүдийг сайжруулан ажиллаж байна. Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэхэд үүсэх			√	

	зардлын тооцоог дахин боловсруулж байна.				
27.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлалын төсөл болон холбогдох баримт бичгийн хамт Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд хуулийн төсөлд ТББ-уудаас ирүүлсэн саналыг тусган ажиллаж байна			√	
28.	Монгол Улсын Засгийн газар ЖАЙКА байгууллагатай хамтран “Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл”-ийг 2021-2025 оны хооронд хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд нь дадлагажуулах хүний нөөцийг бэхжүүлэх тогтолцоо бүрдүүлэх бөгөөд эрх зүйн орчныг бий болгох зорилгоор “Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааг зохицуулах удирдамж”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох талуудын саналыг тусган ажиллаж байна.			√	
29.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбар яамдад шилжүүлсэний дагуу тус яаманд шилжин ирсэн хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын/ахлах/ байцаагчдын албан тушаалын тодорхойлолт, үндсэн чиг үүргийг тогтоох албан тушаалын тодорхойлолтыг тус тус боловсруулж, ажлын хэсэгт танилцуулан, яамны Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэв.			√	
30.	Салбарын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, түүний хэрэглээ, хадгалалтад хяналт тавих журам”-ын төслийг боловсруулан ХНХ-ын сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.			√	
31.	“Салбарын хяналтын улсын (ахлах), байцаагчийн эрх үргэлжлүүлэн олгох, түдгэлзүүлэх, сэргээх, бууруулах, цуцлах журам”-ын төсөл боловсруулж байна.			√	
32.	“Хяналт, шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам”-ын төсөл боловсруулж хавсаралтаар салбарын хяналт шалгалтанд ашиглах хяналтын хуудасны загварын төслийг боловсруулж, батлуулахад бэлтгэв. 1. Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр: 4.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас, 4.6 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас, 2. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 4.1.1 кодтой Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас, 3. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр: 4.2 кодтой Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас, 4.3 кодтой Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.4 кодтой Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолтыг шалгах хяналтын хуудас, 4.5 кодтой Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 4.7 кодтой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас.			√	
33.	Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ыг үндэслэн “Баримт бичгийн нэгдсэн дугаар олгох тухай” зааврын төслийг шинээр боловсруулан холбогдох газраас санал авч байна.			√	
34.	Хяналт, шалгалтын үйл ажиллагаанд ашиглах хэвлэмэл хуудсыг шинэчлэн батлуулахаар 25 хэвлэмэл хуудасны загварыг засварлан боловсруулж, албан бичгийн хамт архивын ерөнхий газарт хүргүүлсэн.			√	
35.	2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан ТХ-08 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хорооны шинээр боловсруулсан 12 стандартыг хэлэлцэх хуралдаанд хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн төлөөлөл оролцсон. Үүнээс MNS 4970:202x Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Эргономик. Гараар гүйцэтгэх ажлын үеийн өргөх ачааны жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5080: 202xХөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага стандартуудад тус бүр 2 саналыг техникийн хороонд өгсөн.			√	
36.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/463 дугаар тушаалаар батлагдсан "Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүсийн жагсаалт" боловсруулах ажлын дэд хэсэгт ажиллан, гадна орчинд үйлдвэрлэлийн хортой нөлөө бүхий технологи ажиллагаатай үйлдвэрийн жагсаалт гаргаж, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай			√	

	барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоох жагсаалтын төслийг боловсруулан, ажлын хэсэгт танилцуулсан.				
II	Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр				
37.	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу бэлтгэн Эдийн засаг, хөгжлийн яаманд цахимаар хүргүүлээд байна.			√	
38.	УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэх хуулийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 24-ний 01/229 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
39.	Засгийн газрын хуралдаанаар 2023 оны 1 дүгээр улиралд хэлэлцүүлэх асуудлын жагсаалтын бэлтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 01/157 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
40.	“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг “Өрхийн амьжиргааны түвшинг харгалзан Монгол Улсын 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 91 хувьд өрхийн мэдээллийн нэгдсэн сан болон төрийн мэдээллийн бусад санг ашиглан олгох болсоноор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Босго шугам шинэчлэн тогтоох тухай” А/05 тушаалыг батлав.			√	
41.	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн журам батлагдсантай холбоотой салбарын бүх түвшний байгууллага, ажилтан хүүхдийн мөнгийг улсын хэмжээнд нэгдсэн нэг ойлголтоор хэрэгжүүлж ажиллах талаарх чиглэлийг боловсруулан ХНХ-ын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 01/126 дугаар албан бичгээр ХХҮЕГ-т чиглэл хүргүүлэв.			√	
42.	“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэрэгжилт, тулгамдсан асуудал”-тай холбоотой танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулав. Уг хуралдаанд хүүхдийн мөнгөний талаар шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг танилцуулсан ба хүүхдийн мөнгийг 91 хувьд багтаан олгох, иргэд, төрийн байгууллагууд олон нийтэд зөв мэдээлэл өгөх, уриалга гаргах талаар ХНХ-ын сайдад үүрэг чиглэл өгсөн.		√		
43.	УИХ-ын гишүүдэд зориулж Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зорилтуудын биелэлтээр “Ярианы сэдэв” бэлтгэн, гишүүдэд хүргүүлэв. Түүнчлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотойгоор хүүхдийн мөнгөнд хамрагдах өрхийг тодорхойлох аргачлал, түүнийг тойрсон шүүмжлэлтэй асуудлууд мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн олголтын талаар мэдээлэл нэмж бэлтгэж өгсөн.			√	
44.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, хүнсний эрхийн бичиг зэрэг мөнгөн дүнг нэмэгдүүлэх шаардлагатай нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн 2023 онд нэмж шаардагдах 87.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн тооцоог гарган тус яамны удирдлагуудад танилцуулав.			√	
45.	Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 100.0 сая ам.долларын санхүүжилттэй “Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр”-ийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлийн талаарх мэдээллийг “Загвар болон хяналтын механизм”-д туссан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гарган 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Сангийн яаманд хүргүүлээ.			√	
46.	Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг танилцуулах 2 удаагийн уулзалтыг Олон улсын байгууллагын болон төрийн бус байгууллагын төлөөллийн хүрээнд зохион байгууллаа. Уулзалтад нийт 60 гаруй байгууллагын төлөөлөл 80 хүн оролцов.			√	
47.	Улсын Их Хурлын чуулганд 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулсан “Ковид-19 цар тахлын үед хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр түүний үр дүн” танилцуулгыг бэлтгэв.			√	
48.	“Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийг Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн 1520 өрхийг хамруулж хэрэгжүүлж байгаа билээ. Уг ажлын хүрээнд тус өрхүүдэд зах зээлийн судалгаа хийж хамтран ажиллах “Айрим”			√	

	судалгааны байгууллага болон төслийн багийнхантай хамтран цахим уулзалтыг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр, танхимын уулзалтыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд хийж ажлын явц, үйл ажиллагааны талаар санал солилцож ажиллав.				
49.	<p>“Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ийн Удирдах Хорооны хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Уг хурлаар төслийн хэрэгжилттэй холбоотой хэд хэдэн асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • төслийн 2022 оны хэрэгжилтийг 2 бүрэлдэхүүн хэсэг, худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, төслийн 2022 оны төсвийн хэрэгжилт, 2023 оны төсвийн төлөвлөлт, • төслийн зээлийн ангиллын дагуу хийгдсэн зарцуулалт, дахин хуваарилах санал, • төслийн хугацаа 2023 оны 12 дугаар сард дуусгавар болж байгаатай холбогдуулан төгсөлтийн туршилтын хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хугацааг сунгах асуудал, • 2023 оны төлөвлөгөөний төсөл, төслийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний дүгнэлт, 2023 оны сунгалт зэргийг хэлэлцүүлсэн. <p>Хурлаар хэлэлцүүлсэний үр дүнд хурлын зөвлөмж гаргаж, ажилтнуудын гэрээг сунгах, тогтоол гаргаж төслийн зээлийн дахин хуваарилалтын саналыг ХНХЯ-аас СЯ, АХБ-руу уламжилж шийдвэрлүүлэх саналуудыг тусган 2023 оны төлөвлөгөөг шийдвэрлүүлэхээр тогтсон.</p>			√	
50.	Дэлхийн банкны ахлах эдийн засагч Марк Дорфман 2023 оны 1 сарын 23-27-ны өдрүүдэд ХНХЯ болон НДЕГ-ын холбогдох хүмүүстэй 3 өдөр уулзалт хийлээ. Марк Дорфман нь 2008 оноос хойш Монгол Улсын нийгмийн даатгал, тэтгэврийн асуудлаар яамтай хамтран ажиллаж хэд хэдэн нийгмийн даатгалын тэтгэврийн тооцооллоор хэд хэдэн судалгаа хийсэн бөгөөд УИХ-д өргөн барьсан Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд санал, өгч хамтран ажиллав. Энэ удаагийн уулзалтаар 2018 оноос хойшхи нийгмийн даатгалын тэтгэвэр авагчдын болон шимтгэл төлөгчдийн дата өгөгдөлд Прост загварчлалаар хийсэн дүн шинжилгээний урьдчилсан дүнг танилцуулж, харилцан санал солилцов. Уулзалтуудад ХНХЯ, НДЕГ-ын холбогдох газрын дарга нар болон мэргэжилтнүүд нийт 28 хүн оролцлоо. УИХ-аар Нийгмийн даатгалын багц хуулийг хэлэлцэж байгаа цаг үед эдгээр уулзалтыг зохион байгуулсан нь хуулийн хэлэлцүүлэгт шаардагдах сүүлийн үеийн тоо, дүн шинжилгээ болон бусад улсын туршлагаас суралцах холбогдох мэдээллээр хангагдсан ач холбогдолтой уулзалтууд болсон.			√	
51.	<p>1.Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэг, Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх журамд заасны дагуу хянан бүртгэлээ.</p> <p>2.Автотээврийн салбарын 2023-2025 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэг, Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх журамд заасны дагуу хянан бүртгэлээ.</p>			√	
52.	Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Ажил олгогчид зориулсан “Хүүхэд, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцаа” сургалтыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ААНБ, компаниудын хүний нөөцийн ажилтнуудыг хамруулан 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулав.			√	
53.	Төрийн албаны цалин хөлсний талаар 2024 онд авах арга хэмжээний санал боловсруулан удирдах албан тушаалтнуудад танилцуулав.			√	
54.	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны анхдугаар хуралдааны бэлтгэл ажлыг хангаад байна. Тус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлж батлуулах юм.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2023 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн төсөл; 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг сонсох, 2023 оны төсвийн хуваарь батлах зөвлөмж гаргах тогтоолын төсөл; 3. Монголын ажил олгогчдын нэгдсэн холбоо, Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэнгийн хамтран боловсруулсан 20 ажил мэргэжлийн стандартын дүгнэлт танилцуулгын төсөл; 4. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөлтэй хамтран “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”, танилцуулгын төсөл. 			√	

55.	Зам тээврийн яамнаас ирүүлсэн “Авто тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журам”-ын төсөлд өгөх санал болон цаашид Монгол Улсын хэмжээнд жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох саналыг боловсруулж, удирдлагуудад танилцуулах шатандаа хэлэлцэгдэж байна.			√	
56.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалын дагуу холбогдох ажлыг хийж, “Ejob” платформын үйл явцын талаарх тайлан мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “Ejob” платформд Бүртгэлтэй ажлын байрны тоо-1373, Ажил хайгчийн тоо-7341, Ажил олгогчийн тоо-2937, Ажилд зуучлагдсан иргэдийн тоо-315 болсон байна. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн сум, хорооны хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан 442 мэргэжилтэнд Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын сургалтыг зохион байгуулав.			√	
57.	“Жайка” Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах санамж бичгийн дагуу “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2023-2027 онд хэрэгжүүлэх тухай баримт бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааг 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулав.			√	
58.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.			√	
59.	Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж байна.			√	
60.	Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. Энэхүү Санамж бичгийн дагуу Зөвлөх үйлчилгээ авах гэрээг байгуулсан бөгөөд цаашид гэрээнд дурдсан 3 дахь ажлын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах, Монгол Улсын онцлогт нийцсэн хуримтлалын нэгдсэн сангийн ерөнхий загвар, хуулийн төслийн агуулгыг хэрхэн гаргах талаар 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй цахим уулзалт хийв.			√	
61.	АХБ, НҮБХАС, Дэлхийн зөн зэрэг олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төслийн төлөвлөгөөнд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тусгуулах шаталсан уулзалт хийсэн. Ингэснээр ОУБ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, төсвийг үр дүнтэй зарцуулах, төрийн зарим чиг үүргийг төсөлтэй хамтран хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.			√	
62.	Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны “Хүүхдийн эрх, хамгааллын судалгааг зохион байгуулах тухай” А/245 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд ДЭМБ-ын судалгааны аргачлалын орчуулгыг хянах, ганцаарчилсан ярилцлага болон хүүхэд хамгааллын асуумжийг сайжруулах ажлыг зохион байгуулж байна.			√	
63.	“Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд” хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх сургалтыг аймаг, дүүрэгт зохион байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлж, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос судалгааг авч байна.			√	
64.	Нийгмийн ажлын мэргэжлийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж байна.			√	
65.	Хорт хавдартай хүүхдийн нийгмийн хамгаалал, эрх зүйн орчны бодлогын шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах ажлыг эхлүүлж, сонгосон зөвлөхүүдтэй уулзалт хийж, зорилтоо тодорхойллоо.			√	
66.	НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 10 дугаар тайланд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийн гишүүдэд төлөвлөгөөний төсөлд санал авах тухай албан тоот хүргүүлсэний дагуу төлөвлөгөөний төслийг нэгтгэж байна.			√	

67.	ЭЗНСЭТухай олон улсын пактын хэрэгжилтийн 5 дугаар тайланг хэлэлцүүлсэн тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, холбогдох баримт бичгийн төслийг ГХЯ, ЗГХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.			√	
68.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Монголын ахмадын холбооны хооронд төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээний төсөлд газруудаас санал авч батлуулахаар ажиллаж байна.			√	
69.	НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн II,III тайлан илтгэлийг 2023 оны III улиралд хамгаалахаар болсон бөгөөд энэ хүрээнд 2020 оноос хойшхи конвенцын хэрэгжилт, Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, богино асуултийн мэдээллийг ирүүлэх тухай 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/235 тоот албан бичгийг хавсралтын хамт хүргүүлээд байна. -Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас боловсруулж буй 2023-2027 онд хэрэгжүүлэх “Монгол Улсын Зохистой хөдөлмөрийн хөтөлбөр”-ийн төсөлтэй уншиж танилцан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар санал боловсруулж хүргүүлээ. -Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлтэй уншиж танилцан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын чиглэлээр хөгжүүлэх, энэ төрлийн үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, Биеийн тамир, спортын тухай хуулийн 19.3-т заасан журмыг боловсруулж батлуулах зэрэг саналыг боловсруулж хүргүүлсэн. -ЮНЕСКО-н Монголын Үндэсний комисстой 2023 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хүргүүлсэн.			√	
70.	Салбарын хяналтын газрын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу “Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, гэрчилгээ олгох журам”, “Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ”-ний загвар, “Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам”-ыг шинээр боловсруулж, сайдаар батлуулахаар бэлтгэсэн.			√	
71.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын харьяа аймаг, нийслэл, дүүргийн орон тооны хязгаар тогтоох асуудлыг судалж, ХНХ-ын сайдын тушаалын төсөл боловсруулан холбогдох газруудаас санал авч байна.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
72.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох дүрэм”-ийг баталсан. Дээрх дүрмийн 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан 516 нийгмийн даатгалын байцаагчид “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/06 дугаар тушаал батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/181 дугаар албан бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.			√	
73.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал 2023 оны 01 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв.			√	
74.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар батлуулах “Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тооцох зөвлөмж батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг 2023 он 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02/260 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.			√	
75.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар батлуулах “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцох зөвлөмжийг батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг 2023 он 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/06 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.			√	

76.	-2023 оны 01 дүгээр сарын 16-нд Eagle TV-д Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал оролцож мэдээлэл өгөв. -2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нийгмийн даатгалын цахимжилтын асуудлаар Боловсрол, шинжлэх ухааны яаманд мэдээлэл өгөв.			√	
77.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг нэгтгэн 2022 оны 1,2,3,4 дүгээр улирал, 2022 оны 12 дугаар сарын байдлаар гаргаж, www.mlsr.mn сайтад байршуулсан.			√	
78.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр) буюу нийтлэг үйлчилгээ, дэмжих арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж боловсруулах хэлэлцүүлгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институт, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар, хэлтсүүдээс холбогдох удирдлага, мэргэжилтнүүд 2023 оны 01 дүгээр сарын 24-25 хооронд оролцож санал, дүгнэлтийг гаргаж хамтран ажилласан.			√	
79.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2023 оны 01 дүгээр сард нийт 47 тусгай зөвшөөрөл хүссэн байгууллагууд хүсэлт ирүүлсэнийг хуульд заасны дагуу нягтлан шалгаж, тусгай зөвшөөрөл олгох эсэхэд дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгээр хуралдуулж, дүгнэлт гаргуулаад байна.			√	
80.	НҮБ-ын Нийгмийн хөгжлийн хорооны 61 дүгээр чуулганд “КОВИД-19 ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХ ЯВЦЫГ ХУРДАСГАХ БОЛОН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2030 ХӨТӨЛБӨРИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БҮЙ ТЭГШ БУС БАЙДЛЫГ АРИЛГАХ АРГА ЗАМ БОЛОХ ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ ӨНДӨРТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ БҮЙ БОЛГОХ НЬ” сэдэвт илтгэлийг боловсруулан хүргүүлэв.			√	
81.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 13-нд зохион байгуулж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан. -Эрүүл мэндийн салбарт хийгдсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийн дүнг үндэслэн “ЗӨВЛӨМЖ”-ийг баталж, салбарын яам болон орон нутагт хүргүүлсэн. -ХАБЭА-н үндэсний хорооны 2022 оны тайлан болон ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний гүцэтгэлийг тус тус хэлэлцсэн.			√	
82.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Чиглэл өгөх тухай” 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг гарган Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр ажиллаж байна.			√	
83.	Нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн салбар хооронд цахим мэдээлэл солилцох, мэдээллийн агуулгыг шинэчлэх, шинээр солилцох мэдээллийг тодорхойлох үүрэг бүхий холбогдох яамд, агентлаг, төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулах тухай ХНХ-ын сайдын тушаалын төсөл, удирдамжийг боловсруулан танилцуулж байна.			√	
84.	Улсын Их Хурлын чуулганаар Коронавируст цар тахал (Ковид -19)-ын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хэлэлцэхтэй холбоотой 2020-2022 онд нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлсэн арга хэмжээ, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлүүд, хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгийн мэдээлэл, холбогдох бусад арга хэмжээний талаар танилцуулга, мэдээллийг боловсруулж танилцуулав.			√	
85.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад магадлан итгэмжлэл олгох Орон тооны бус зөвлөлийн хурлыг зохион байгуулж, Магадлан итгэмжлэл авахаар материалаа ирүүлсэн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний баримт бичигт үнэлгээ хийв. Нийт 106 байгууллагаас 88 нь магадлан итгэмжлэгдсэн. Үүнээс Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 60, Ахмад настанд үзүүлэх халамжийн үйлчилгээнд 28 , гэр асрамж халамжийн үйлчилгээнд 1 иргэнд тус тус магадлан итгэмжлэх эрх олгосон.			√	
86.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жил бүр гэрээ, төлөвлөгөө батлуулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд				

	хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний төслийг, мөн 2022 онд хамтран ажилласан тайланг гарган Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Мөн 2023 онд байгуулах гэрээ, төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.			√	
87.	Төрийн таван байгууллагын захиргааны мэдээлэл ашиглан Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91%-д олгох болсонтой холбогдуулаад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт Шуурхай удирдлагын баг ажиллахаар болсон тул тус багт ажиллах алба хаагчдын нэрсийг авахаар Үндэсний статистикийн хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төвд 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02/128 дугаар албан бичиг хүргүүлсэн.			√	
88.	Засгийн газрын 2023 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төвийн төлөөлөл хуралдаж “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж хэрэгжилтийг ханган, иргэд, олон нийтийг мэдээллээр ханган, өргөдөл гомдолд хариу өгч ажиллав.			√	
89.	И-Халамж, И-Монголиа системээр дамжуулан хүүхдийн мөнгөнд хамрагдах эсэхийг шалгах үйлчилгээний ажлын даалгавар гаргах болон үйлчилгээг тестлэх, нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэв.			√	
90.	Өрхийн мэдээллийн сангийн программ хангамжийг тестлэх, зарим шаардлагатай өөрчлөлт хийх ажилд дэмжлэг үзүүлэв.			√	
91.	ХНХ-ын сайдын 2019 оны А/57 дугаар тушаалыг үндэслэн Тайгад амьдардаг цаатан иргэнд олгодог тэтгэмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Цагаан нуур сумаас авч нэгтгэн, тайлан, мэдээллийг гаргав.			√	
92.	Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа байнгын асаргааны тэтгэмжид /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ хамрагдаж байгаа 34991 иргэний мэдээллийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэлтэй тулгалт хийхэд ажил олгогчоос шимтгэл төлсөн 1441 иргэн байна. Эдгээр иргэдийн тэтгэмжийг хэрхэн шийдэх талаар Ерөнхий сайдын зөвлөх Ч.Ундрахбаяр, яамны холбогдох газар, хэлтсүүд, ХХҮЕГ, НДЕГ, ХБХХЕГ-ын дарга, мэргэжилтнүүд, дүүргийн ХХҮХ-ийн хяналтын мэргэжилтнүүд оролцсон уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар асаргааны тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн судалгаа, мэдээллийг илүү дэлгэрэнгүй, нарийвчилж гаргасны үндсэн дараагийн шийдвэр гаргах талаар хэлэлцэв.			√	
93.	Аргачлалын загварыг турших зорилгоор 5 байгууллагын 7 мэдээллийн санг нэгтгэн бүрдүүлсэн өрхийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох тооцоолуудыг хийж, тухай бүр удирдлагуудад танилцуулж ажилласан.			√	
94.	Нийгмийн халамжийн тайлангийн маягтад Үндэсний статистикийн хорооноос гарсан саналтай холбоотойгоор тухай бүр холбогдон мэдээлэл өгч, холбогдох саналыг тусгаж ажилласан. Мөн Сангийн яамнаас тус маягтад санал авахаар хүргүүлсэн.			√	
95.	Хүүхэд, хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, маягтыг нөхөх зааврыг холбогдох байгууллагуудтай хамтран шинэчлэн боловсруулав.			√	
96.	Цахим бүртгэлийн системийн шинэчлэлтэй холбогдуулан гадаадаас ажиллах хүч авах улирлын мэдээний маягтыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.			√	
97.	Өндөр насны тэтгэвэр авагчдын тоогоор 2 постер, Нийгмийн даатгалд хамрагдсан иргэдийн талаарх 1 постер, Нийгмийн даатгалын сангийн орлого талаарх 1 постер, Албан журмаар даатгуулсан иргэдийн талаарх 1 постер, Нийгмийн даатгалын сангийн зарлагаар 1 постер, Сайн дураар даатгуулсан иргэдийн талаарх 1 постер, Нийт тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээ авагчдын талаарх 1 постер, Тэтгэвэр авагчийн дундаж тэтгэвэр талаарх 1 постер, Тэтгэвэр авагчдын тоогоор 1 постер тус тус бэлтгэв.			√	
98.	Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас боловсруулан ирүүлсэн Төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь газар хэлтэс, тасгаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам, үйлчилгээний жагсаалт болон мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загварыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж харьяа агентлагуудаас санал авч нэгтгэн хүргүүлэв.			√	

99.	Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан хооронд баталсан “Улс орны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөлтийн саналыг хүргүүлсэн.			√	
100.	“Дэлхийн зөн Монгол” ОУБ-тай хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгч, уулзалт зохион байгуулсан.			√	
101.	ОУХБ, ОУХЭЗБ-уудтай уулзалт хийж, 2023 онд хамтран хэрэгжүүлэх ажлын санал солилцох уулзалтуудыг зохион байгуулсан.			√	
102.	2023 оны 2 дугаар сарын 6-15-ны өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо болох НҮБ-ын Нийгмийн хөгжлийн хорооны 61 дүгээр чуулганы Ерөнхий хэлэлцүүлэгт залуучууд, гэр бүл, ахмад настны чиглэлээр Сайдын хэлэх үгийн төслийг бэлтгэв.			√	
103.	Соёлын яамнаас зохион байгуулсан Угийн бичгийн асуудлаарх зөвлөлгөөнд оролцож, удмын сан, угийн бичгийн асуудлаар хэрхэн хамтран ажиллах, ойрын үед хийх ажлын талаар санал солилцов.			√	
104.	Монгол Улс, АНУ-ын эдийн засгийн зөвлөлдөх уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-“АНУ-ын Эмэгтэйчүүдийн дэлхийн хэмжээнд хөгжих, өсөн дэвжих санаачилга (WGDP)-д Монгол Улс нэгдэх боломжийг судлах” ажлыг хэрэгжүүлэх ажлын тайлан гаргав.			√	
105.	Сангийн яаманд ХХТХ-ийн шинэчилсэн найруулгатай холбоотой хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик үзүүлэлтийг нэгтгэн хүргүүлэв.			√	
106.	Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хүүхдийн хөдөлмөрийн сургалт болон Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр санал солилцох уулзалтыг зохион байгуулав.			√	
107.	-Хүүхдийн тусламжийн утас-108, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө өгөв. Мөн үйлчилгээний чанар хүртээмж, 108 утасны дуудлагын хариу үйлчилгээ, кейс шийдвэрлэлтийн асуудлаар агентлаг, нийслэл, дүүргийн газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг хийв.			√	
108.	“Хүүхдийн эрх, хамгаалал” судалгааны ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, хэвлэлийн мэдээ боловсруулж, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.			√	
109.	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг боловсруулсан.			√	
110.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэгийг шалгаруулах журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд уг арга хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Арга хэмжээнд УИХ-ын болон ЗГ-ын гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн дарга, гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий 430 гаруй хүн оролцсон. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2022 оны хуралдаанаас гарсан тогтоол, тэмдэглэл, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дэд болон салбар зөвлөлүүдэд хүргүүлсэн.			√	
111.	-АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд баригдаж буй 6 төвийн барилгыг хүлээн авах, үйл ажиллагааг нь эхлүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, дэд сайдаар батлуулсан. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороотой байгуулсан хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан газруудаас санал авахаар ажиллаж байна.			√	
112.	-Саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг Улаанбаатар хотын хэмжээнд судалж, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр үнэлгээ хийх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/190 дүгээр тушаалаар баталсан. Энэ хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт байрлах төрийн ордон, бүх яам, нийслэлийн ЗДТГ-ын зам, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийг үнэлсэн бөгөөд 3 дэд ажлын хэсэг байгуулан ажилласан. Одоогоор дэд ажлын хэсгүүдээс ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэж байна. -Түгээмэл хөгжил төв НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Коммисарын газартай хамтран зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрны эрх мониторингийн судалгаа”-ны ажлын тайлан хэлэлцэх уулзалтад оролцож, мэдээлэл солилцлоо.			√	

	-БХБЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хуралд оролцож, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгсөн.				
113.	-Засгийн газрын 33 дугаар тэмдэглэлийн жилийн эцсийн тайлангийн биелэлтийг нэгтгэж байна. -Конвенцын тайлан хамгаалах бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан төлөвлөгөөний төслийг боловсруулсан.			√	
114.	-ЖАЙКА "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хамтарсан зохицуулах зөвлөлийн хуралд оролцож төслийн хүрээнд 2023 онд хийх үйл ажиллагаанд санал өгсөн. -БШУЯ-наас зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх салбар дундын уулзалт хэлэлцүүлэг"-ийн хүрээнд дэд сайд С.Зулпхарын хэлэх үг, мэдээллийг боловсруулж, хэлэлцүүлэгт оролцсон. -Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комиссын хуралд оролцож, үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцлаа. -Эрхэм нандин сувд ТББ-ын зохион байгуулж байгаа ХБ-тэй хүүхдийн талаар хэрэгжүүлэх Бодлогын барим бичиг боловсруулах судалгааны ажлын хэлэлцүүлэгийг хамтран зохион байгуулсан. -ЖАЙКА "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-өөс зохион байгуулсан Нийслэлийн дунд ангийн багш нарыг чадавхжуулах цуврал сургалтад оролцсон 300 гаруй багш, Зориг сангийн Залуу манлайллын хөтөлбөрийн 20 гаруй оролцогч, Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн ТББ-ын ажилтнуудад "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт"-ыг зохион байгууллаа. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлалыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал" сэдвээр онлайн сургалт зохион байгууллаа. Уг сургалтад 40 гаруй эцэг эх оролцлоо.			√	
115.	Баянзүрх дүүргийн Цагдаагийн Газраас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 28ж/90 тоот албан бичгээр ирүүлсэн А.Амарсайхан, Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02/26 тоот албан бичгээр ирүүлсэн Шивээ-Овоо ХК-ийн ажилтан О.Тэмүүжиний үйлдвэрлэлийн ослын акт тогтоолгох хүсэлтийн дагуу тус газрын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын судлан бүртгэсэн үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулсан. Мөн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэл систем /om.inspection.gov.mn/-д бүртгэсэн.			√	